

“Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тулгамдаж буй саад бэрхшээлийг тодорхойлох судалгаа”-ны тайлан

2022.03.28

Судалгааны үндэслэл, зорилго, дизайн:

Монгол Улсын Их хурлын 2018 оны 56 дугаар тогтоол, Засгийн газрын 250 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалт хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг сайжруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдан ажиллаж байна. 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, тэдэнд тулгарч буй саад тогтор, тэдний хэрэгцээний талаар нотолгоо цуглуулж, бодлого боловсруулагчид, олон нийтийн ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх, холбогдох хууль, бодлого болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөлөх зорилготой ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд сурч боловсрох эрхийн талаарх нотолгоонд суурилсан судалгаа хийх шаардлагатай болсон юм.

Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд тэгш хамруулах талаарх сургуулийн орчны ойлголт, хандлага, суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад тулгамдаж буй саад бэрхшээл, сургуулийн орчны дэд бүтэц, хүртээмж, сургалтын хэрэглэгдэхүүний нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зорилгоор 2022.03.01-2022.03.10-ны өдрийн хугацаанд Улаанбаатар хотын БЗД-ийн нутаг дэвсгэр дээрх ерөнхий боловсролын 10 сургуулийн түвшинд тандалт судалгааг хийж үр дүнг 2022.03.11-2022.03.28-ны хооронд дүгнэж, санал зөвлөмжийг боловсруулж ажиллалаа. Судалгааг ХБХХЕГ-ын Хөгжил, нийгмийн оролцооны газар хариуцан зохион байгуулж, судлаачаар ХБХХЕГ-ын мэргэжилтэн Х.Сансармаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны ..., дадлагын оюутан ... нар ажиллаж, судалгааны үр дүнд санал зөвлөмжийг ХБХХЕГ-ын дэд дарга Д.Ганболд, ХНОГ-ын дарга Б.Амаржаргал, ХБХЭЭХ-ны гүйцэтгэх захирал С.Сэлэнгэ нар боловсруулж ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага, тэгш хамруулах үзэл санааны талаарх үзэл баримтлал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэгш хамруулах боловсролд хамрагдалтын талаарх сэтгэл ханамж, үр дүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад сургуулийн орчин дахь саад бэрхшээл,

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад шаардлагатай арга хэмжээ, дэмжлэгийг анги удирдсан багш, анги хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн удирдлага, сургалтын менежер, боловсролын яам, холбогдох төрийн байгууллага, бусад иргэний нийгмийн байгууллага, БЗД-ийн ЗДТГ-ын түвшинд тодорхойлох зорилгоор 10 ерөнхий боловсролын (21, 30, 44, 53, 59, 79, 84, 92, 111, 133) 124 сургалтын менежер, нийгмийн ажилтан, эмч, анги удирдсан багш, бусад багш нар хамруулан анкетын аргаар (Хавсралт 1.), хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ... эцэг эхчүүдтэй ганцаарчилсан ярилцлага (Хавсралт 2.) хийж, сургуулийн орчны дэд бүтэц, хүртээмжийн зураг авалт (Хавсралт 3.) хийж судалгааг зохион байгуулж ажиллалаа.

Энэхүү судалгааны үр дүнд нотолгоонд суурилсан судалгааны тайлан, дүгнэлт, санал зөвлөмжийг боловсруулж, олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэх юм. Хэлэлцүүлгийн үр дүнд тэгш хамруулах боловсролын хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлж ажиллана.

Судалгааны түүвэр, ерөнхий хэв шинж:

Анкетын судалгаанд анги удирдсан багш (47.5%), мэргэжлийн бусад багш нар (35.5%), сургалтын менежер, нийгмийн ажилтан, эмч (17.0%) хамрагджээ. Оролцогчдын ерөнхий бүтцийг харвал: 20-30 нас (13.7%), 31-49 нас (30.6%), 40-49 нас (34.7%), 50-59 нас (21%), эрэгтэй 7.3%, эмэгтэй 91.9%, бакалаврын боловсрол (64.5%), магистр (33.1%), мэргэжлийн зэрэггүй (29.0%), заах аргач (54.8%), тэргүүлэх зэрэгтэй (8.9%), зөвлөх зэрэгтэй (3.2%) байна. Боловсролын салбарт ажилласан жилээр нь авч үзвэл 1-5 жил (9.7%), 6-10 жил (33.9%), 11-19 жил (22.6%), 20 ба түүнээс дээш жил ажилласан багш (33.9%) байна (Хүснэгт 1.).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий хэв шинж

Нас	Хүйс	Боловсролын түвшин	Мэргэжлийн зэрэг	Ажилласан жил
20-30 нас (13.7%)	эрэгтэй 7.3%	бакалаврын боловсрол (64.5%)	мэргэжлийн зэрэггүй (29.0%)	1-5 жил (9.7%)
31-49 нас (30.6%)	эмэгтэй 91.9%	магистр (33.1%)	заах аргач (54.8%)	6-10 жил (33.9%)
40-49 нас (34.7%)			тэргүүлэх зэрэгтэй (8.9%)	11-19 жил (22.6%)
50-59 нас (21%)			зөвлөх зэрэгтэй (3.2%)	20 ба түүнээс дээш жил ажилласан багш (33.9%)

Судалгааны үр дүн:

1-р зорилт болох судалгаанд оролцогчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага, тэгш хамруулах үзэл санааны талаарх үзэл баримтлал ямар түвшинд байгааг судалж үзэхэд:

Хөгжлийн бэрхшээл гэдэг нь эрхтэн системийн учир дутагдалтай байдал (62.1% нь маш их болон санал нийлж байна), хувь хүний тулгамдсан асуудал (33% нь заримдаа), нийгмийн зүгээс үзүүлэх саад бэрхшээл (38.2% нь заримдаа) гэж хариулж байгаагаас үзэхэд хөгжлийн бэрхшээлийг илүү хувь хүний асуудал харах хандлага байсаар байгааг илтгэж байна. Хөгжлийн бэрхшээл нь ганцхан хувь хүний асуудлаас үл хамааран нийгмийн бусад саад бэрхшээлтэй нийлж бэрхшээл гэдэг зүйлийг үүсгэж байгаа асуудал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нэг ангид хэд суралцах боломжтой гэвэл тэгш хамруулах үзэл санааны хүрээнд хэдэн ч хүүхэд суралцах боломжтой байж болох юм. Гэвч Монгол Улсын өнөөдрийн түвшинд нэг ангид 1-2 хүүхдээс илүү суралцах боломж хязгаарлагдмал байгааг сургалтын менежер, анги удирдсан багш нарын хариултаас харж болох юм (1 хүүхэд суралцахад илүү тохиромжтой гэж хариулсан нь 62 буюу 50%, 2 хүүхэд суралцахад илүү тохиромжтой гэж хариулсан нь 55 буюу 44.4%).

Судалгаанд оролцогчдын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хандах хандлага, ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ойлгож хүлээн авах, тэдэнд боловсрол эзэмшүүлэх хүсэл эрмэлзэл ерөнхийдөө эерэг байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна (Явж чадаж л байвал хэдэн цаг ч хамаагүй танхимаар сургууль дээрээ хичээллэх гэж 52 буюу 41.9%, танхим болон гэрийн сургалтыг хослуулах гэж 24 буюу 19.4% хариулсан байна). Гэхдээ бас заавал сургууль дээрх ирэх албагүй, гэрээр нь очоод тодорхой хугацаанд хичээлийг заах, зөвхөн гэрээр нь заах, сургууль дээр тодорхой цаг байлгах гэж нийт судалгаанд оролцогчдын 33.9% нь хариулж байгаа нь тэгш хамруулах үзэл баримтлалыг хараахан бүрэн хэмжээнд ойлгож хүлээн аваагүйн илрэл юм.

2-р зорилт болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэгш хамруулах боловсролд хамрагдалтын талаарх сэтгэл ханамж, үр дүнг тодруулж авч үзэхэд:

Нийгэм-хамт олонтой болж, мэдлэгийн хүрээ тэлж, дэмжлэгийг оновчтой өгвөл суралцах нөхцөл бүрдэж чадаж байгаа нь нийт судалгаанд оролцогчдын 86.8% хариулснаас харагдаж байна. Гэхдээ тусгай орчин нөхцөл шаардаж, саад бэрхшээлүүдтэй их тулгарч байгаа учраас тусгай сургуульд нь сургах нь зүйтэй гэж үзсэн хариулт 12.9% эзэлж байгаа нь тэгш хамруулах боловсролын талаарх үзэл хандлага төдийлөн бүрэн дүүрэн төлөвшөөгүйг илтгэж байна (Хүснэгт 2.).

Хүснэгт 2. Тэгш хамруулах боловсролд хамрагдалтын талаарх сэтгэл ханамж, үр дүнгийн түвшин

Нийгэм-хам олонтой болж байна	70.7%
Мэдлэгийн хүрээ тэлж байна	4.0%
Дэмжлэгийг оновчтой өгвөл суралцах нөхцөл бүрдэж байна	12.1%
Тусгай орчин нөхцөл илүү шаардаж байна	10.5%
Саад бэрхшээлүүдтэй их учирч байгаа тул тусгай сургуульд явуулах нь шаардлагатай байна.	2.4%

3-р зорилт болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад сургуулийн орчин дахь саад бэрхшээлийг тодруулж авч үзэхэд:

Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага дутмаг байдал, анги удирдсан багшийн арга зүй хангалтгүй, үе тэнгийнхний сургалт, нөлөөллийн ажил хангалтгүй, холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмын талаарх мэдээлэл дутмаг, дэд бүтэц, орчны хүртээмжгүй байдал, багшийн нэмэгдэл цалин урамшуулал олгохгүй байх, хэрэгцээтэй сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, дэмжлэгийн багийн үйл ажиллагаа тодорхойгүй, нэг багшид ногдох хүүхдийн тоо (нийт хүүхдийн эзлэх тоо) их зэрэг асуудлууд дийлэнх олонх буюу 50%-иас дээш судалгаанд оролцогчдын хариулснаас харагдаж байна (Хүснэгт 3.).

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад нөлөөлж буй сургуулийн орчин дахь саад бэрхшээлүүд

Саад бэрхшээлүүд	Маш их, их, дунд зэрэг	Бага зэрэг, огтгүй
Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага дутмаг	76.6%	
Анги удирдсан багшийн арга зүй хангалтгүй	72.6%	
Үе тэнгийнхний сургалт, нөлөөллийн ажил хангалтгүй	69.4%	
Холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмын талаарх мэдээлэл дутмаг	67.3%	
Дэд бүтэц, орчин нөхцөл хангалтгүй	66.1%	
Багшийн нэмэгдэл цалин урамшуулал олгодоггүй	60.5%	
Хэрэгцээтэй сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж хангалтгүй	57.2%	
Дэмжлэгийн багийн үйл ажиллагаа тодорхойгүй	50.1%	
Бусад: Нэг ангид ногдох хүүхдийн тоо маш их	50.0%	
Харилцан туршлага хуваалцах, уулзалт хийдэггүй		56.4%
Гэр бүлийн дэмжлэг тусалцаа хангалтгүй		62.1%

4-р зорилт болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад шаардлагатай арга хэмжээ, дэмжлэгийг тодруулахад:

- Дэмжлэгийн багтай эцэг эхчүүд илүү нягтарч хамтарч ажиллах, дэмжлэгийн багийн бүрэлдэхүүнд мэргэжлийн зөвлөх багш, мэргэжилтнүүд болох эмч, сэтгэл зүйч, хөдөлгөөн, хэл засалчдыг байлгах зайлшгүй шаардлагатай байгаа талаар судалгаанд оролцогчдыг дийлэнх 80 гаруй хувь нь хариулжээ.
- Мөн анги удирдсан багш, нийгмийн ажилтан, сургалтын менежер, сургуулийн захирлууд голлох чиглүүлэгч үүрэгтэй байх нь чухал талаар нийт судалгаанд оролцогчид 100% хариулжээ.
- Тогтмол санхүүжилтийг хийж байх нь зайлшгүй чухал талаар судалгаанд оролцогчдын 89.5% хариулж байгаагаас үзэхэд санхүүжилт маш чухал болох нь харагдаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй анги удирдсан багшийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголт, мэдлэгээ дээшлүүлэх, ахиц, амжилтыг үнэлэх, тооцох, шаардлагатай хичээлийн хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, анги танхимаар хангагдах, нэмэгдэл цалин урамшуулал авах, эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг, хамтын ажиллагаа, багшийг удирдлагын зүгээс ойлгож дэмжих, багшийн ажлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах хэрэгцээ шаардлага байна. Зарим багш нар нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тусгай сургууль шаардлагатай байгааг дурдсан байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зарцуулах цаг гаргах боломжийг бүрдүүлэхийн тулд нэг багшид ногдох хүүхдийн тоог бууруулж, нэг ангид 1-2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байх боломжтой талаар нийт судалгаанд оролцогчдын 94.4% хариулснаас харагдаж байна. Зарим тохиолдолд нэг багшид 4-5 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцуулж буй тохиолдол байна.
- Анги хамт олны зүгээс хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, мэдлэгээ дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг байгаагаар нь ойлгож хүлээн авах, хэрхэн туслах арга зам, хамтран суралцах, ялгаварлан гадуурхахгүй харилцах, дэмжих талаарх мэдлэг, мэдээллээ нэмэгдүүлэх талаарх сургалт, мэдээлэл, хамтран ажиллах нөхцөл боломж бүрдүүлэх шаардлагатай байна гэж судалгаанд оролцсон нийт сургуулийн удирдлага, сургалтын менежер, анги удирдсан багш нарын 100% нь хариулжээ.
- Сургуулийн удирдлага, менежер, нийгмийн ажилтны зүгээс багш нартаа онол, арга зүйн сургалт явуулах, харилцаа, хандлагаа өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх дэлгэрэнгүй судалгаатай болох, холбогдох хууль эрх зүй болон цаг үеийн мэдээллээр тогтмол хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болгож

өгөх, анги удирдсан багш нарыг дэмжиж, урам өгөх, нэмэгдэл цалин урамшууллыг тогтмол олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөлийг бүрдүүлж өгөх, сурлагын амжилтыг үнэлэх үнэлгээнд тохируулга хийж өгөх, хүүхэд сургуульдаа орж гарах орц, гарцыг налуу замаар солих, унаа гаргаж өгөх, ариун цэврийн байгууламж бэлдэж өгөх, туслах багшаар хангаж өгөх, нэг багшид ногдох хүүхдийн тоог цөөрүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нэг ангид тэгш хуваарилах, ангид багшийн ажилд хяналт тавьж, зөвлөгөө өгөх, бусад эцэг эхчүүдэд анги дүүргэлт, багшийн ажлын нөхцөлийн талаар мэдээлэл хийж өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулах шаардлагатай талаар анги удирдсан багш нарын зүгээс санал дэвшүүлжээ.

- Эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийн хувьд сургуулийн дотоод дүрэм журам, цагийг чандлан баримтлах, хүүхдийнхээ багштай нягт хамтарч ажиллах, багшийг ойлгож хүлээн авах, хүүхдийнхээ талаарх бүрэн ойлголт, мэдээлэлтэй болох, багшийн зүгээс тавьж буй шаардлагыг биелүүлэх, хүүхдийнхээ сурлагын ялгаатай хэрэгцээний талаарх нөхцөл байдлыг мэргэжлийн байгууллагаар оношлуулах, хүүхдээ хүлээн зөвшөөрөх, хүүхдээ ойлгож, тусалж дэмжих, өөрсдөө сэтгэл зүйн дэмжлэг тусалцаа авах, гэрт өгсөн гэрийн даалгавар, дасгалыг хийлгүүлэх, давтуулахад анхаарах, хичээлийн хэрэгсэл, бэлтгэлийг хангадаг байх, хүүхдээ нийгэмшүүлэх хөгжүүлэх хөтөлбөрүүдэд хамруулдаг байх, хэрвээ хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй бол нуухгүй байх, аль болох ялгаатай байдлыг нь эрт илрүүлж, эрт тусламж, дэмжлэг авдаг байх тал дээр анхаарах шаардлагатай талаар судалгаанд оролцогчид 100% санал нэгтэй хариулсан байна.
- Боловсролын яам, холбогдох төрийн байгууллага, бусад байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд албан ёсоор багш нарыг арга зүйн сургалтад хамруулах, шаардлагатай төсөв, санхүүг шийдвэрлэж өгөх, хангалттай төсөв хуваарилж өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд амрах тусгай тохижуулсан өрөөг сургууль бүр дээр бий болгох, сургуулийн орчны дэд бүтэц, хүртээмжийг сайжруулах, хичээлийн хэрэглэгдэхүүн ном, сурах бичиг, гарын авлаг, биет үзүүлэн тараах материалаар хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн зөвлөгөө өгдөг мэргэжилтэн бэлтгэж өгөх, багшийн нэмэгдэл цалин урамшууллыг олгож тогтмолжуулахад анхаарч ажиллах, багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн талаар олон цагаар заах, туслах багшаар хангах, сурагчдыг хөгжүүлэх нэмэлт дугуйлан секц, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай талаар судалгаанд оролцогчид санал дэвшүүлсэн байна.

- Нэмэгдэл цалин урамшуулал, хичээлийн тохируулгат ширээ, сандал, тусгай орчин бүхий өрөө бэлдэх, ариун цэврийн байгууламж байгуулах, налуу зам, шатны бариул бий болгох, хичээлийн туслах хэрэглэгдэхүүн, гарын авлага бэлтгэх, тоглоом, телевизор худалдан авах, нэмэлт мэргэжлийн чиглэлийн тухайлбал, сэтгэл зүйн, амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх, харилцаа, хандлагын сургалт авах сургагч багшийн зардал, олон талт нөлөөллийн арга хэмээ зохион байгуулах төсөв, хүүхдийн ар гэртэй холбогдох утсаар ярих гэх мэт хөрөнгө санхүүтэй холбоотой зардлыг шийдвэрлэх шаардлагатай талаар тухайн сургуулийн удирдлага, багшийн зүгээс хариулжээ.
- Дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулахад анги удирдсан багшийн үйл ажиллагаатай нягтарч хамтарч ажиллах, бусад хороо, эмнэлэг, төрийн байгууллагууд, сургуулийн удирдлагуудтай хамтрах, цалингаас гадна нэмэгдэл цалинтай байх, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлагаа нэмэгдүүлэх, цаг үеийн мэдээллээр хангагдах, туслах багшийн орон тоог бий болгох, туршлага судлах, ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйд суралцах шаардлагатай юм байна.
- Судалгаанд оролцсон сургуулийн удирдлага, сургалтын менежер, анги удирдсан багш, бусад багш нарын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад БЗД-ийн ЗДТГ-ын зүгээс дараах ажлуудыг хийх шаардлагатай байгаа талаар санал гаргажээ. Үүнд:
 - Олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажил зохион байгуулах
 - Тэгш хамруулан сургах хууль, дүрэм, журмыг сурталчлах
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нэн тэргүүнд албан ёсоор оношлох
 - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын мэдээллийн сантай болох
 - Сургууль тус бүрт туршлагатай чиглүүлэгч багш олгох
 - Мэргэжлийн багш нартай холбуулан нэгдэн ажиллах
 - Сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжтой эсэх талаар нөхцөл байдлын судалгаа хийх
 - Судалгааны үр дүнд гудамж талбай, сургуулийн налуу замыг янзлах
 - Сургууль болгонд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах төсөв гаргаж өгөх

- Багшид өгөх нэмэгдэл цалин, урамшууллыг шийдвэрлэх
- Сайн хэрэгжүүлж буй сургуульд тодорхой хэмжээний урамшуулал өгөх
- Багш нарыг арга зүйгээр хангах сургалт зохион байгуулах (дохионы хэл, брайл үсэг гэх мэт.)
- Нэг ангид ногдох хүүхдийн тоог бууруулах
- Багш нарын бодит байдлыг нүдээр харах, танилцах арга хэмжээ зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тодорхой хандив, дэмжлэг үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүрэн гүйцэд хамруулах ажлыг нэн тэргүүнд зохион байгуулах
- Эцэг эхчүүдэд чиглэсэн зөвлөгөө, хүүхдээ ойлгож, оношлуулах, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт явуулах
- Гарын булчин хөгжүүлэх тоглоомоор хангах
- Мэргэжлийн хөдөлгөөн, хэл засалч бий болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн стресс тайлах, тайвшруулах, хөгжүүлэх өрөө гаргаж өгөх
- Хүүхэд хүргэж өгөх, авах унаа гаргаж өгөх
- Сургуулийн эргэн тойрны гудамж талбайг аюулгүй зорчихоор тохижуулах

5-р зорилт болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад эцэг эхийн байр суурь, сэтгэл ханамж, эцэг эхийн үүрэг оролцоо, гэр бүлийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, шаардлагатай дэмжлэг, тусалцааг тодруулахад:

Ганцаарчилсан ярилцлагад оюун ухаан, хэл яриа, суралцахуйн, саажилттай, тулгуур эрхтний, эпилепситэй, дауны хам шинжтэй, хараа, сонсголын бэрхшээлтэй 6-15 насны, 1-8-р ангийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй нийт 60 эцэг эх, асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамрагдлаа. Сургуульд суралцаж буй жилээр нь харахад ихэвчлэн бага ангийн, сургууль завсардаагүй, байнга хичээлдээ явж байгаа, харин дунд ангийн хүүхдүүдийн хувьд ердөө 3 хүүхэд хамрагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад эцэг эхийн байр суурь, сэтгэл ханамжийг тодорхойлж үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн ерөнхий боловсролын сургуульд сурч байгаадаа ихэд баяртай байгаа нь нийт судалгаанд оролцогчдын 90% хариулснаас харагдаж байна. Тэд суралцаж байгаадаа, багшийн харилцаа, хандлага, хоорондын ойлголцол, анги хамт олны дэмжлэгт маш их талархаж байдаг байна.

Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцахад зарим саад бэрхшээлүүдтэй тулгарч байгааг эцэг эх, асран хамгаалагчдын хариулт дахин баталж байна. Тухайлбал,

- Хичээлээ ойлгохгүй байдал
- Даалгавраа бие дааж гүйцэтгэж чадахгүй байдал
- Сургуулийн суралцах орчин нөхцөл, аюулгүй байдал, дэд бүтэц, хүртээмж хангалтгүй байна.
- Монгол хэл, тоо гэхээсээ илүү хүүхдийн бие бялдар, гоо зүй, урлагийн мэдрэмж хөгжүүлэх чиглэлийн дуу хөгжим, уран зураг, хэл засал, хөдөлгөөн заслын хичээлүүд огт орохгүй байна.
- Хүүхдийнхээ оношийг мэдэхгүй тул хүүхдээ хаана оношлуулахаа мэдэхгүй
- Хүүхдүүд ихэвчлэн хичээлдээ ирж, явахдаа явган явах нь хүндрэлтэй байдаг.
- Сургуулийн удирдлагын зүгээс ямар нэгэн санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй
- Дүүрэг, хорооноос үзүүлэх дэмжлэг хангалтгүй байна.

Эцэг эхийн үүрэг оролцоо, гэр бүлийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг тодруулж авч үзэхэд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 3 тохиолдолд архины хамааралтай, 1 тохиолдолд өвөө нь зоддог, хүчирхийлэл, дарамтад өртсөн байх магадлалтай хүүхэд илрээгүй, гэр бүл, дийлэнх ээж, аавуудын хувьд ажилгүй гэртээ байдаг байна. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ хичээлийг ойлгуулахын тулд зарим тохиолдолд өөрсдөө бичиг үсэг мэдэхгүй, ихэвчлэн яаж хичээл заах арга зүй мэддэггүй тул хэрхэн гэрийн даалгавраа хийлгүүлэх, яаж туслахаа мэддэггүй байна. Аль болох тусалж, дэмжиж, гэр бүлийн гишүүд болох ах, эгч, туслах боломжтой нэгнээс тусламж хүсч суралцах үйлийг дэмждэг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нарт шаардлагатай дэмжлэг тусалцааг тодруулахад:

- Бэрхшээлийн төрлөөс хамаарч хүүхдүүд сургуульд суралцах, амжилтаа үнэлүүлэх, үзэж буй хичээлүүд нь ялгаатай байдаг байх
- Хичээлийн хоцрогдолгүй, хичээлээ бүрэн дүүрэн ойлгодог, чанартай боловсрол авдаг байх

Шигтгээ 1.

Би том болоод загвар бүтээгч, би ирээдүйд эмч болоод бүх хүмүүсийг эмчлэхийг хүсдэг.

Судалгаанд оролцсон хүүхдийн ярианаас...

- Хүнийг зөвхөн академик чадвар бус математик, монгол хэл биш бусад гоо зүй, урлаг, уран сайхны мэдрэмж хөгжүүлэх чиглэлийн нэмэлт дугуйлан, хөтөлбөрүүдийг явуулах
- Эцэг, эх, асран хамгаалагч нарт хүүхдээ асрах санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх
- Хэл засал, хөдөлгөөн заслын үйлчилгээг нэвтрүүлэх
- Хүүхэд сурах нөхцөл боломжийг бүрдүүлж, багшид туслах, дэм өгөх
- Туслах багшийн орон тоог гаргаж өгөх
- Хүүхдээ оношлуулах, хаашаа явах, зам гарц зааж өгөх
- Дуу хөгжим, уран зургийн хичээлд тохиргоо хийх
- Хичээлийн хоцрогдол арилгах нэмэлт дугуйлан секц явуулах

Шигтгээ 2.

Хөгжим сурмаар байвч кабинет нь 3 давхарт, номын сан нь мөн адил тул манай хүүхэд тэргэнцэртэй учраас хичээлдээ орж чаддаггүй.

Эцэг эхийн ярианаас...

Шигтгээ 3.

Сургууль руу очих зам, машины зогсоол байхгүй тул хаяа хичээлдээ очих боломжгүй болох үедээ хичээлээсээ хоцорч, дараа нь нөхөж авахад маш хүндрэлтэй байдаг. Тэгээд бүр хичээлээсээ хоцорчихдог.

Судалгаанд оролцсон хүүхдийн ярианаас...

- Зарим тохиолдолд сургалтын менежер, нийгмийн ажилтны харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулах

Шигтгээ 4.

Нийгмийн ажилтан сургуулийн нэр баллах юм ярьчих ваа гээд байдаг.

Эцэг эхийн ярианаас...

Мөн судлаач (хоёр сургуульд 1 судлаач буюу нийт 5 судлаач судалгаа авсан болно.) нарын ганцаарчилсан ярилцлага хийж байх явцад олж авсан мэдээлэл, мэдрэмж, ажиглалтын явцын тэмдэглэлд үндэслэн дараах нөхцөл байдлыг тодруулж ажиллалаа. Үүнд:

- Гол ажигласан зүйл бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж яг хэнийг хамруулахаа мэдэхгүй, ангид муу сурч байгаа хүүхдүүдийг хамруулж байна. Өөрөөр хэлбэл, суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулж ойлгож байна. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад үнэндээ тохируулга шаардаж байгаа нь үнэн тул албан ёсоор үүнийг хөгжлийн бэрхшээлийг ангилалд оруулах нь зайлшгүй болсон байна.

Шигтгээ 5.

Сургуулийн бүртгэлд хөгжлийн бэрхшээлтэй гэж бүртгэгдсэн 97 хүүхэд байгаа боловч, үүний 10 гаруй нь албан ёсоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссоор оношлогдсон, бусад нь суралцахуйн бэрхшээлтэй байх (жинхэнэ болон жинхэнэ бус) юм.

Судлаачийн ажигласан тэмдэглэлээс...

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд албан ёсоор оношлогдоогүйн улмаас ангийн ахиц, амжилтын үнэлгээнд доогуур үзүүлэлт үзүүлж нөлөөлдөг, багш нэмэгдэл цалин урамшуулал, ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж ажиллаж чаддаггүй, дэмжлэгийн баг бүрдээгүй байдаг байна. Энэ нь нэг талаас эцэг эхчүүдийн хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй гэж хүлээн зөвшөөрөхгүй байгаа хандлага, хүүхдээ хаана оношлуулах арга зам, хэнд хандахаа мэдэхгүй байгаагаас шалтгаалдаг. Нөгөө талдаа нууж, эсвэл хүүхдээ мэдэхгүйгээр сургуульд өгөөд суралцах явцад хүүхдийн ялгаатай байдал ажиглагдахаар илэрдэг байна. Энэ тохиолдолд багш эсвэл эцэг эх, асран хамгаалагчид хаана оношлуулах талаар тэр бүр мэдээлэлтэй байдаггүй байна. Зарим оношилгооны газар өндөр төлбөртэй байдаг талаар дурджээ.

Төсөл хэрэгжиж байгаа сургуулиудын хувьд:

- Сургалтын арга зүйн хувьд илүү хүүхэдтэй ажиллах чиглэлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материал
- Тохилог тухтай хүүхэд амраах өрөө, чөлөөт цаг өнгөрүүлэх газар
- Тухайн хүүхдийн түвшинд даалгавар боловсруулах арга зүйд суралцах
- Мэргэжлийн сэтгэл зүйч, нарийн мэргэжлийн зөвлөгөө чухал байхад

Төсөл хэрэгждэггүй сургуулиудын хувьд:

- Сургалтын менежер, нийгмийн ажилтан, анги удирдсан багш болон бусад багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт, мэдлэг дутмаг, хандлага байхгүй
- Багшийн нэмэгдэл цалин урамшуулал авдаггүй. Учир нь хүүхдээ албан ёсоор оношлуулаагүй, хаана яаж оношлуулахаа мэдэхгүй.
- Сурагчдыг ахицаар үнэлдэггүй, яахаа мэдэхгүй байдалд ордог.

Шигтгээ 6.

Багшид олгодог нэмэгдэл цалин урамшуулал болох 10 хувиа яаж авдаг вэ?, үүнийгээ яаж авах вэ? гэж асуухад сургалтын менежерийн зүгээс анги удирдсан багшийг шууд шагнаж, чи энэ талаар асуух ёсгүй гэж уурласан.

Судалгааны үеэр...

- Хүүхдийг оношлуулж явах цаг байхгүй, эцэг эх, асран хамгаалагчдад нь үүрэгдэхээр эцэг эх, асран хамгаалагч нар хаана, хэнд хандахаа мэдэхгүй
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал нь зөвхөн анги удирдсан багшийн асуудал гэж үзэх, бусад багш нарын хувьд хамааралтай асуудал биш
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэхээр ангид муу сурч байгаа хүүхдүүдийг судалгаанд хамруулах
- Муу сурч байгаа гэдэг нь суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулж ойлгож байгаа боловч тэдгээр хүүхдүүд нь албан ёсоор оношлогдоогүй
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ таних, яаж ажиллах, ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах арга зүй байхгүй, мэргэжлийн багш нарын туслалцааг их хүссэн
- Хүүхэд хөгжүүлэх, ядаж стресс тайлах, амраах өрөө байхгүй

- Нэг ангид 40-50 хүүхэдтэй тул түүний хажуугаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ үйлчлэхээр бусад эцэг эхчүүдээс гомдол ирдэг.
- Нэг ангийн багшид 4-5 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хуваарилж өгдөг, тэгш хуваарилалт байдаггүй
- Суралцах орчин, нөхцөл, анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, орц, гарц, налуу зам байхгүй тул хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахаас хаширсан.

Шигтгээ 7.

Саад бэрхшээл их байгаа учир тусгай сургуульд явуулах шаардлагатай байна. Ялангуяа хүнд хэлбэрийн хүүхдүүдийг.

Судалгаанд оролцсон багшийн ярианаас...

- Эцэг эхчүүдэд чиглэсэн багш, эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа чухал тухай сургалт хийх
- Сургуулийн удирдлагын хувьд туршлага судлах, бусадтай хамтран ажиллах шаардлагатай байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бага ангидаа хамрагдалт их байдаг юм байна. Харин дунд ангид ерөнхийдөө 1-3 хүүхдүүд суралцаж байна. Энэ нь дунд ангийн багш нарын хичээлийг ойлгодоггүйтэй холбоотой байдаг тул хүүхдүүд сургуульд завсардахад хүрдэг байна.
- Дэмжлэгийн баг бүрдсэн гэх боловч гишүүдийн үзэл хандлага тэгш хамруулахын үзэл баримтлалын эсрэг, байхгүй гэж байгаа нь дэмжлэгийн багийн тухай мэдэхгүй, гишүүдийн үндсэн үүрэг, хүүхэдтэйгээ ажиллах арга зүй байхгүй

Шигтгээ 8.

Дэмжлэгийн багийн гишүүн нь яагаад энэ хүүхдүүдийг тусгай сургуульд нь сургахгүй байгаа юм бэ? гэж асуусан.

Судалгааны явцын тэмдэглэлээс...

- Сургуулийн орчны нөхцөл байдлыг тодруулсан зарим зургийг хавсаргав.

Дүгнэлт

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж хэн бэ? энд хэнийг хамруулахаа мэдэхгүй, суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг хамруулж байгаа нь суралцахуйн бэрхшээлийг албан ёсоор оношилж, хөгжлийн бэрхшээлийн ангилалд нэвтрүүлэх болсныг илтгэж байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хаана, хэнд хандаж албан ёсоор оношлуулах төрийн байгууллагын тогтолцооны талаарх мэдээлэл дутмаг байна. Эцэг эх, асран хамгаалагч нарын хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй гэж хүлээн зөвшөөрөх сэтгэл зүй бэлтгэгдээгүй, бусдаас нуух, эсвэл хаана, хэнд хандах талаарх мэдээлэл дутмаг байна. Энэ талаар эцэг эх, асран хамгаалагчдын багш нартай хамтарч ажиллах хамтын ажиллагаа сул байна.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал нь зөвхөн анги удирдсан багшийн асуудал биш юм, энэ нь сургуулийн бүх хүмүүст хамааралтай асуудал. Сургуулийн удирдлага, сургалтын менежер, нийгмийн ажилтнууд, эмч, анги удирдсан багш, бусад багш нарын тэгш хамруулах боловсролын талаарх үзэл баримтлал бүрэн дүүрэн төлөвшөөгүй, дэмжлэгийн багийн үйл ажиллагаа тодорхой бус, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай хэрэгцээнд тохируулан ажиллах арга зүй, ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах, хүүхдээ таньж харилцах арга техник учир дутагдалтай байна. Төсөл хэрэгжиж байгаа, төсөл хэрэгждэггүй сургуулийн хооронд ойлголтын зөрүү, хандлага, удирдлагын менежментийн зөрүү асар их байна.

4. Төсөл хэрэгжүүлдэг сургуулийн хувьд сургалтын хэрэглэгдэхүүний хувьд арай өөр түвшний туслах материал, хөгжүүлэх тоглоом, амрах өрөө зэрэг шаардлагатай байхад төсөл хэрэгжүүлдэггүй сургуулиудын хувьд ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах арга зүй, ойлголт хандлага, хүүхдийг оношлох, суралцах орчин нөхцөл бүрдүүлэх налуу зам, шатны бариул зэрэг шаардлагатай байна.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ахицаар үнэлэх асуудлыг тэр бүр мэдэхгүй байна. Зарим тохиолдолд стандартын дагуу шаардлагыг сургуулийн зүгээс тавьж байна.

6. Сургалтын хөтөлбөр, агуулгын хувьд зөвхөн академик боловсрол (математик, монгол хэл) гэхээсээ илүү хүүхдийн мэдрэмж, гоо зүй, урлаг уран сайхныг хөгжүүлэхэд чиглэсэн дуу хөгжим, уран зураг, нэмэлт дугуйлан секц, хөгжүүлэх хөтөлбөрүүд, бие бялдрын хөгжлийг сайжруулахад чиглэсэн хэл засал, хөдөлгөөн заслын нэмэлт үйлчилгээнүүд шаардлагатай байна.

7. Багш нар нэмэгдэл, цалин урамшууллаа авч чадахгүй байна. Энэ нь нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй гэж оношлогдсон хүүхдүүдийн хувьд яригдаж байна. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг албан ёсоор оношлогдоогүй, бичиг баримтын бүрдэл буюу ганцаарчилсан төлөвлөгөө хийгдээгүй, үр дүн, явцаа

үнэлүүлээгүйн улмаас багш нэмэгдэл цалин урамшууллаа авч чадахгүй байсаар байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийг мэдсээр байж сургуулийн удирдлагын хандлагаас шалтгаалж байна.

8. Нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ажлын цагийн ачаалал их, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ зарцуулах цаг шаардлагатай буюу туслах багшийн хэрэгцээ маш их байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах боловсролын үйлчилгээнд хамруулахад нэг ангид 1-2 хүүхэд байвал илүү тохиромжтой байдаг байна. Зарим тохиолдолд 4-5 хүүхэд байгаа нь тухайн багшийн ажлын ачааллыг эрс нэмэгдүүлдэг байна. Нөгөөтэйгүүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн хувьд хувийн туслалцаа, үйлчилгээ үзүүлэхэд (бие засуулах, амраах, түргэн тусламж гэх мэт.) нь туслах багшийн хэрэгцээ маш их байгаа юм байна.

9. Эцэг эхчүүдийн хувьд нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ талаарх хайр халамж сул, сургуульд оролцох оролцоо бага, багштай нягтарч хамтарч ажиллах хандлага сул, хүүхдийнх нь ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж буйд дургүйцэх хандлага их, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах, гэрийн даалгаврыг заах арга зүй дутмаг, яаж хөгжүүлэх арга замаа мэдэхгүй, тэднийг дэмжих сургууль, дүүрэг, хорооны зүгээс үзүүлэх санхүүгийн дэмжлэг байхгүй байна.

10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн бага ангийн элсэлт нь дунд ангийн элсэлтээс харьцангуй их байна. Учир нь бага ангид анги удирдсан багшийн зүгээс ганцаарчилсан хөтөлбөр хэрэгжүүлж, сургалтын тохируулга хийж ажиллаж байхад дундын мэргэжлийн бусад багш нар тэр бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй тохируулга хийж хичээл заадаггүй байна. Үүнтэй холбоотойгоор тухайн хүүхэд хичээлээ ойлгодоггүй тул сургууль завсардах үндсэн шалтгаан болдог байна.

11. Сургуулийн орчны дэд бүтэц, хүүхэд гэрээс сургууль явах зам, орц, гарц, налуу зам, шатны бариул гээд хүүхдийн суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх асуудал маш хангалтгүй байна. Багшийн хичээл заахад хэрэглэгдэхүүн сургалтын тоног төхөөрөмж, туслах хэрэглэгдэхүүн, шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлага, жишиг даалгаврын сан, үзүүлэн тараах материал, хүүхэд хөгжүүлэх тоглоом, тайвшруулах өрөө, хөгжүүлэх төвүүд шаардлагатай байна.

12. Судалгаанд оролцогчдын ажилласан жил, мэргэжлийн зэргээс харахад мэргэжлийн заах аргач, тэргүүлэх зэрэгтэй багш (63.7%), ажилласан жилээрээ дийлэнх нь 6 ба түүнээс дээш, 20 ба түүнээс жил ажилласан багш нар байгаа хирнээ тэгш хамруулах боловсролын талаарх үзэл баримтлал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, хөгжүүлэх талын мэдээлэл учир

дутагдалтай байгаа нь багш бэлтгэх, багшийг мэргэшүүлэх үйл ажиллагаандаа анхаарах болсныг харуулж байна.

13. Мэргэжил дээшлүүлэх, шаардлагатай сургалтын чиглэлүүдийг тодруулбал:

- Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал, зарчим, ухагдахуун
- Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах, хөгжүүлэх арга зүй
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах
- Ганцаарчилсан төлөвлөгөөний загвар, жишиг даалгаврын сан бэлдэж өгөх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх нэгдсэн үнэлгээний загвар, холбогдох журмуудын танилцуулга, мэдээлэл
- Холбогдох хууль эрх зүйн ойлголт, мэдээлэл
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй харилцах, сөрөг зан үйлд хэрхэн дасан зохицох арга зүй
- Анги хамт олныг хэрхэн нийгэмшүүлж, хөгжүүлэх
- Эцэг эхчүүдийн ойлголт, хандлагыг өөрчлөх, холбогдох хууль эрх зүйн мэдээлэл өгөх

Хавсралт

1. Анкетын арга

2. Ганцаарчилсан ярилцлагын чиглэл

3. Сургуулийн орчны зураг